

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/117/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 129
танай _____ ны № _____ Т

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА З.НАНДИН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1 болон 8 дугаар зүйлийн 8.1 дэх зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

006020154

Өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 174.6 сая төгрөгөөр өссөн нь 3 их эмч, ээлжийн сувилагч гэсэн 3 орон тоо дутуу ажилласан мөн 2022 онд цар тахалтай холбоотой зардал бага гарснаар хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 12 зорилтын хүрээнд 35 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 93 хувьтай дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,832,144.28	374,353,756.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	55,978,257.96	230,629,283.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	55,978,257.96	230,629,283.76
3121	Төгрөг	55,978,257.96	230,629,283.76
31211	Төрийн сангийн харилцах	55,978,257.96	230,629,283.76
35	БАРАА МАТЕРИАЛ	119,288,886.32	143,724,473.15
351	Түүхий эд материал	72,127,149.85	101,729,887.38
35110	Тусгай зориулалттай материал	12,930,792.20	15,626,356.16
35130	Эм боох материал	59,196,357.65	86,103,531.22
354	Хангамжийн материал	45,691,736.47	40,524,585.77
35410	Бичиг хэргийн материал	330,050.00	162,200.00
35420	Аж ахуйн материал	32,998,445.27	33,807,835.27
35430	Сэлбэг хэрэгсэл	4,185,000.00	4,185,000.00
35460	Хүнсний материал	4,739,241.20	2,369,550.50
35600	Мал амьтад	1,470,000.00	1,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	472,888,142.57	432,152,026.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,888,142.57	432,152,026.97
392	Биет хөрөнгө	463,903,142.57	423,617,026.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,901,459.57	281,901,459.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,189,255.46)	(48,748,429.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,034,656.00	67,034,656.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(42,805,923.02)	(48,492,055.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,964,059.93	210,983,527.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,736,132.30)	(78,926,439.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,904,564.86	40,379,564.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,107,764.81)	(11,478,288.03)
39209	Зам, гүүрийн байгууламж	15,677,803.20	15,677,803.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,479,725.40)	(5,454,171.00)
39217	Ном	739,400.00	739,400.00
393	Биет бус хөрөнгө	8,985,000.00	8,535,000.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(375,000.00)	(825,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,010,000.00	8,010,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	736,720,286.85	806,505,783.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	735,949,562.02	806,505,783.88
51	Засгийн газрын хувь оролцоо	735,949,562.02	806,505,783.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,459,592.29	208,459,592.29
51101	Өмч: - төрийн	8,010,000.00	8,010,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	331,171,424.83	401,727,646.69
51210	Өмнөх үеийн үр дүн	331,171,424.83	331,171,424.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	70,556,221.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,318,544.90	196,318,544.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	736,720,286.85	806,505,783.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,235,616,495.66	613,224,814.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	401,695,935.66	90,402,156.12
122	Тусламжийн орлого	387,618,715.56	90,402,156.12
122001	Хандив тусламж /дотоод/	86,863,229.33	7,345,028.00
122002	Хандив тусламж /гадаад/	300,755,486.23	83,057,128.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	833,920,560.00	611,387,658.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	385,825,100.00	1,389,848.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,232,730.00	1,389,848.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,603,690.00	59,939,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,603,690.00	59,939,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,824,070.00	550,058,710.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,824,070.00	461,493,710.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	918,191,834.92	542,668,592.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	918,191,834.92	542,668,592.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	892,531,834.92	627,911,547.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,238,295.34	265,225,098.40
210101	Үндсэн цалин	158,513,108.94	175,138,189.07
210102	Нэмэгдэл	106,863,524.57	71,350,475.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,919,000.00	3,544,999.20
210104	Урамшуулал	51,942,661.83	15,191,435.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,864,966.96	34,909,258.33
210201	Тэтгэврийн даатгал	25,050,488.25	24,012,479.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,475,762.60	2,824,996.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,957,089.99	1,953,354.96
210204	Ажилгүйдлийн даатгал	488,900.87	539,799.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,892,725.25	5,578,628.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,260,700.00	54,624,055.25
210301	Гэрэл, цахилгаан	5,105,943.00	3,945,182.05
210302	Түлш, халаалт	49,984,605.00	50,192,010.00
210303	Цэвэр, бохир ус	170,152.00	486,863.20
2104	Хангамж, бараа материалын зардал	28,375,336.57	22,571,759.00
210401	Бичиг хэрэг	2,190,850.00	1,468,950.00
210402	Тээвэр, шатахуун	11,765,176.57	13,546,484.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,282,800.00	1,192,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,324,000.00	2,185,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	379,060.00	111,000.00
210408	Бараа материал акталсны зардал	9,433,450.00	4,067,225.00
2105	Нормативт зардал	396,139,095.36	86,494,012.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	381,414,406.26	80,384,722.23
210502	Хоол, хүнс	14,196,689.10	5,797,290.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	528,000.00	312,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,823,990.00	15,213,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	151,400.00	24,000.00
210604	Урсгал засвар	3,672,590.00	15,189,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,088,180.00	2,542,000.00
210702	Дотоод албан томилолт	2,088,180.00	2,542,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,098,196.00	1,497,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,523,800.00	877,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,500.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,643,074.69	144,834,843.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,885,060.00	3,319,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,758,014.69	52,950,843.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,660,000.00	3,322,044.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,322,044.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,322,044.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	317,424,660.74	70,556,221.86
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	317,424,660.74	70,556,221.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	745,355,560.00	611,631,087.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	243,429.60
120	Нийтлэг татварын бус орлого	-	243,429.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	243,429.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	243,429.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	745,355,560.00	611,387,658.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,260,100.00	1,389,848.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,667,730.00	1,389,848.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,603,690.00	59,939,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,603,690.00	59,939,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,824,070.00	550,058,710.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,824,070.00	550,058,710.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	638,371,062.04	432,110,361.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	638,371,062.04	432,110,361.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,711,062.04	428,788,317.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,467,570.51	266,239,252.05
210101	Үндсэн цалин	160,579,766.20	175,248,460.63
210102	Нэмэгдэл	104,796,867.31	68,625,887.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,919,000.00	3,292,999.20
210104	Урамшуулал	51,171,937.00	19,071,904.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,864,966.96	34,909,259.11
210201	Тэтгэврийн даатгал	24,185,264.25	24,012,479.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,692,068.60	2,824,996.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,130,134.76	2,146,595.89
210204	Ажилгүйдлийн даатгал	532,162.10	539,799.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,325,337.25	5,385,388.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,260,700.00	54,624,055.25
210301	Гэрэл, цахилгаан	5,105,943.00	3,945,182.05

210302	Түлш, халаалт	49,984,605.00	50,192,010.00
210303	Цэвэр, бохир ус	170,152.00	486,863.20
2104	Хангамж, бараа материалын зардал	19,074,936.57	19,459,684.00
210401	Бичиг хэрэг	2,192,400.00	1,404,100.00
210402	Тээвэр, шатахуун	11,765,176.57	13,546,484.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,282,800.00	1,192,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,600,800.00	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,233,760.00	2,896,300.00
2105	Нормативт зардал	150,443,652.00	33,149,531.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	134,215,849.00	28,311,731.64
210502	Хоол, хүнс	10,095,803.00	3,427,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,132,000.00	1,410,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,477,850.00	12,473,000.00
210604	Урсгал засвар	6,971,990.00	12,473,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,088,180.00	2,542,000.00
210702	Дотоод албан томилолт	2,088,180.00	2,542,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,448,196.00	1,497,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,523,800.00	877,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,500.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,585,010.00	3,894,015.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,585,010.00	3,894,015.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,660,000.00	3,322,044.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,322,044.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,322,044.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	106,984,497.96	179,520,725.80
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,356,240.00	4,869,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,356,240.00	4,869,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,356,240.00	4,869,700.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,869,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(52,356,240.00)	(4,869,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	54,628,257.96	174,651,025.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		55,978,257.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,978,257.96	230,629,283.76

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь
-----	----------	----------------	-----------------------	-------------------	---------------------

		оруулсан капитал			оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	331,171,424.83	735,949,562.02
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	331,171,424.83	735,949,562.02
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	70,556,221.86	70,556,221.86
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	401,727,646.69	806,505,783.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	671240300.00	433658017.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671240300.00	428788317.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671240300.00	428788317.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340404100.00	266239252.05
210101	Үндсэн цалин	192167600.00	175248460.63
210102	Нэмэгдэл	106297200.00	68625887.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6615000.00	3292999.20
210104	Урамшуулал	35324300.00	19071904.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42271200.00	34909259.11
210201	Тэтгэврийн даатгал	29710200.00	24012479.40
210202	Тэтгэмжийн даатгал	3135800.00	2824996.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2508700.00	2146595.89
210204	Ажилгүйдлийн даатгал	627100.00	539799.21
210205	Эрүүл мэндийн даатгал	6289400.00	5385388.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49539100.00	54624055.25
210301	Гэрэл, цахилгаан	4000000.00	3945182.05
210302	Түлш, халаалт	45039100.00	50192010.00
210303	Цэвэр, бохир ус	500000.00	486863.20
2104	Хангамж, бараа материалын зардал	47010000.00	19459684.00
210401	Бичиг хэрэг	4760400.00	1404100.00
210402	Тээвэр, шатахуун	26706100.00	13546484.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,700.00	1,192,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,400.00	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,695,400.00	2,896,300.00
2105	Нормативт зардал	99,739,200.00	33,149,531.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,789,200.00	28,311,731.64
210502	Хоол, хүнс	13,940,400.00	3,427,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,009,600.00	1,410,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,835,100.00	12,473,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,335,100.00	-
210604	Урсгал засвар	17,500,000.00	12,473,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,700,400.00	2,542,000.00

210702	Дотоод албан томилолт	4,700,400.00	2,542,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,224,500.00	1,497,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,513,400.00	877,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,096,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,219,600.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	184,800.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,237,500.00	-
210807	Газрын төлбөр	40,800.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,516,700.00	3,894,015.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,516,700.00	3,894,015.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453,497,072.60	606,997,810.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	393,557,972.60	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	393,557,972.60	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,939,100.00	56,939,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	59,939,100.00	56,939,100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь 3 зорилго дэвшүүлэн ажиллажээ.

- ✓ Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх
- ✓ Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл амьдрах дадал хэвшилд сургах
- ✓ Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, дундаж наслалтыг уртасгах сумын эрүүл мэндийн төв болоход оршино

Тус байгууллага нь 5 зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх
- Эмзүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн зорилттой ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын ажилтантай тус хяналт нь өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66.3 сая төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	55,978,257.96	230,629,283.76	(174,651,025.80)
Авлага	88,565,000.00		88,565,000.00
Бараа материал	119,288,886.32	143,724,473.15	(24,435,586.83)
Үндсэн хөрөнгө	472,888,142.57	432,152,026.97	40,736,115.60
Нийт хөрөнгө	736,720,286.85	806,505,783.88	(69,785,497.03)
Өр төлбөр	770,724.83		770,724.83
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	208,459,592.29	208,459,592.29	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	736,720,286.85	806,505,783.88	(69,785,497.03)

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Мөнгөн хөрөнгө 174.6 сая төгрөгөөр өссөн нь 3 их эмч, ээлжийн сувилагч гэсэн орон тоо дутуу ажилласан мөн 2022 онд цар тахалтай холбоотой зардал бага гарснаар хэмнэлт үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Улсын төсвөөс 650.3 сая, орон нутгийн төсвөөс 59.9 сая, нийт зарлагыг 710.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 710.2 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 39 сая төгрөгөөр бууруулж, 671.2 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч тоног төхөөрөмж худалдан авах буюу үндсэн хөрөнгө бэлтгэх зардлаас хасаж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 39 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 80 арга хэмжээг санхүүжүүлэхээр 671.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 436.9 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, жилийн эцсийн мөнгөн хөрөнгө 230.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 436.9 сая төгрөг буюу 70 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 234 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ногдох нормативаар /80302/	278263500	245229777.60	-33033722.4	88
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ /81603/	177262200	193891970	16629770	109
3	Нэмэлт, Дээд шатны төсвөөс хуваарилагдсан /83603/	167858200	167858200	0	100
4	Байр ашиглалтын тогтмол зардал/80111/	56939100	56939100	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь 490 хүн үзлэгт хамруулахаас 150 хамруулж 37.5 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Элэг бүтэн Монгол”	0	В, С вирусийг халдварыг бууруулах	37.5	0	0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу **Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн** 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.5 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 432.1 сая төгрөгөөс 80 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж мөн байгууллагын дотоод сүлжээг ашиглаж байгууллагын бичиг хэргийн зардлыг өмнөх оноос 788.3 мянган төгрөгөөр хэмнэсэн зэрэг арга хэмжээ авч ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 оны Шилэн дансны мэдээллийн Шилэн дансны тухай хуулийн дагуу бүрэн мэдээлж ажиллажээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Томилолтоор явсан анхан шатны баримтын бүрдэлгүй батлагдсан төсвийн зориулалт бус зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлж энэ хүү зөвлөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 29 тоот албан бичгээр биелэлтийг хангаж ажиллажээ.

4.5.1 Завсрын аудитын талаар

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь өмнөх аудитаар 2 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлж энэ хүү зөвлөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 29 тоот албан бичгээр тогтоосон хугацаанд биелэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	
Албан шаардлага	1	119,303,276	1	119,303,276	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн		292,189,170		292,189,170	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад бараа материалын зардлын дансанд андуурч бүртгэсэн 862.9 мянган төгрөгийн бичилтийн алдааг¹ залруулсан.

Аудитаар нийт 12.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 0.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Үүнээс хууль хяналтын байгууллагат шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардлаас 142.0 мянган төгрөгийн томилолтын хуудсыг цаад газраар болон тус төвийн даргаар хаалгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.
2. Батлагдсан төсвөөс 370.0 мянган төгрөгөөр байгууллагын ажилчдын зураг угаалгаж зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.
3. Тэгш тэнцэл холбоо НҮТББ байгууллагаас сургалт авахаар 100.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн боловч анхан шатны баримтгүй мөн сургалт аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

5.2 Албан шаардлага бичгдээгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтгүй 720,000 төгрөгийн эм худалдан авсан.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ЭМТ	4	1,332.0	3	612.0	0	0	1	720.0				
Дүн	4	1,332.0	3	612.0	0	0	1	720.0				